

**“Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит бус хурлын
Тэмдэглэл**

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11:15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ж.Батмөнхийн гудамж, Велокс оффис, 8 давхарт эхлэв.

Хурлын дарга Ц.Наран-Учрал: 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуралдсан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргасан ба хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Батхуягийг, Тооллогын комиссын даргаар Н.Ганзориг, гишүүдээр С.Оюунгэрэл, Б.Гантулга нарыг томилсон байна. Хурлын даргаар томилогдсон Д.Батхуяг нь Хөвсгөл аймгийн Тариалан сум руу яаралтай ажлаар явсан учраас энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй нөхцөл байдал үүссэн. Иймд миний бие ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хурлын үйл ажиллагааг удирдаж ажиллана.

Тооллогын комиссын дарга хувьцаа эзэмшигчдийн ирцийн мэдээллийг өгч, Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Н.Ганзориг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд Саналын эрх бүхий 14,950,655/15,734,200 хувьцаанаас компанийн халаасны 783,545 ширхэг хувьцааг хассан дүн/ ширхэг энгийн хувьцаанаас 10,803,387 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 14 хувьцаа эзэмшигч өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн байгаа нь компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн 72,3% болж байна.

Хурлын дарга: За хурлын ирц хуульд заасан нөхцөлийг хангаж байна, хурлын хэлэлцэх асуудалдаа орё.

“Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах нэг л асуудлыг хэлэлцэнэ. Та бүхэнд дүрмийн төсөл, дүрэмд орж байгаа өөрчлөлтийг харьцуулсан хүснэгтээс харж болно. Тэндээс өөрчлөгдөж байгаа зүйл заалтыг тодорхой харж байна. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон хэрэгцээ шаардлага нь хамгийн гол нь компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсээд байгаа, гадаад худалдаа, тэжээл, бордооны чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тухайн үйл ажиллагааны чиглэлд дүрэмдээ тусгасан байж дараа дараагийн зөвшөөрөл авах нөхцөл бүрддэг. Ийм учраас гол нь компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах зорилгоор, нэгэнт дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа учраас редакцын шинжтэй, техникийн шинжтэй, үг хэллэгийг хуульд нийцүүлэхтэй холбоотой засваруудыг мөн оруулсан, гэхдээ дүрмийн 25 хувиас хэтрүүлэхгүйгээр өөрчлөлт орсон байгаа. Дүрмийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асууж тодруулах зүйл байвал ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас тодруулж болно.

За мөн ТУЗ-ийн хараат бус гишүүн Энхтогтох, гишүүн Мандхай нар өнөөдрийн хуралд оролцож байна

Хурлын дарга: Дүрмийн нэмэлт, өөрчлөлтөөс асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч Мягмарсүрэн: Дүрмийг өөрчлөх болсон гол шалтгаан нь бордоотой холбоотой байна уу?

Хурлын дарга: Хамгийн анхны сэдэл нь тийм. Бордоо, азотын бордоотой холбоотой үйл ажиллагаа эрхлэхэд дүрэмдээ тусгаж, зөвшөөрөл авч эрхлэх учраас компанийн дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулахаар болсон.

Нарийн бичгийн дарга: Компани гадагшаа экспортод бараа бүтээгдэхүүн гаргах зөвшөөрөл хөөцөлдөх явцад манай компанийн дүрэмд бичигдсэн байгаа үйл ажиллагааны чиглэл тохирохгүй байна, гадаад дотоод худалдаа гэсэн чиглэл чинь нэр нь өөрчлөгдөөд төлбөр болон гэрээний үндсэн дээр эрхлэх бөөний худалдаа гэдэг нэртэй болсон, дүрмийнхээ үйл ажиллагааны чиглэлийг хууль тогтоомжид, сүүлд батлагдсан журамд нийцүүл гэдэг шаардлага тавиад манай экспортод бараа борлуулах хүсэлтийг хүлээж авахаас цааргалаад байгаа. Тийм болохоор үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж хэрэгцээ, шаардлага болон хууль журамд нийцүүлэх гэдэг үндэслэлээр дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа, мөн ганц нэг нэмэлт, өөрчлөлт туссан, дүрмийн үг хэллэг, зөв бичгийн алдаа гэх зэрэг засваруудыг оруулсан. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хөндсөн өөрчлөлт байхгүй байгаа.

Хурлын дарга: За дүрмийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуулт, санал байхгүй бол тогтоолын төсөл уншиж танилцуулъя. (Тэмдэглэл хөтлөгч:Хурлын дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дугаартай тогтоолын төслийг уншиж танилцуулав.)

Хурлын дарга: Та бүхэнд тогтоолын төсөлтэй холбоотой санал байна уу? За байхгүй байна, санал хураах ажилдаа оръё. Саналын хуудсыг бөглөх зааврыг тооллогын комиссоос өгнө.(тэмдэглэл хөтлөгч:Тооллогын комиссын дарга Н.Ганзориг санал хуудас бөглөх зааврыг өгөв.)

Хурлын дарга: Тооллогын комисс та бүхний өгсөн саналыг нэгтгэж дууссан, дүнгээ танилцуулах гэж байна.

Тооллогын комиссын дарга Н.Ганзориг: Тооллогын комиссын дүнг танилцуулъя.

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дугаартай “Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай” тогтоолыг батлах асуудлаар:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
хувь	тоо	хувь	хувь	тоо	хувь
10,803,387	100%				

Хурлын дарга: Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж, тогтоолоо баталлаа, та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Шийдвэрлэсэн нь: "Хөвсгөл Алтан дуулга" ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дугаартай тогтоолыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

Хурлын дарга: Хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хаасныг мэдэгдье.

(тэмдэглэл хөтлөгч: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 12 цаг 45 минутад өндөрлөв)

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:
Хурлын дарга
Тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Ц.Наран-Учрал

М.Зулзаяа